



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/9.09

Мандалговь

“Малчдын өдөрлөг-2022” арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, Дундговь аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3, “Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөний зорилт 3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан аймгийн “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 08 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Луус суманд 5 дугаар сарын 13-14-ний өдөр зохион байгуулагдах “Малчдын өдөрлөг-2022” арга хэмжээнд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Арга хэмжээнд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100790